

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/334/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn
	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: Otgonbayarda@audit.gov.mn
	Б энд С аудит ХХК-ийн Захирал Д.Заяажаргал Утас: 99050268 Цахим хаяг: info@bcauditllc.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 390
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА Н.НАРАНБААТАР
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж, шалгагдагч байгууллагаас хараат бусаар ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй 769.5 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/77 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/824 дүгээр захирамжаар Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн үйл ажиллагааг Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлгийн бүтцэд нэгтгэсэн байна.

C:\Users\narangus\Desktop\Бичир хараг 2026\2026\word\1423950099

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Хөрөнгө шилжүүлэх тухай Нийслэлийн Засаг даргын захирамж хүлээгдсэнээс төвийн барилга болон тээврийн хэрэгсэл санхүүгийн тайланд үлдэгдэлтэй байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг 12.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<u>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</u>	4	112,108,123.12	-
Төрийн сангийн харилцах		112,108,123.12	
<u>АВЛАГА</u>	5	105,474,777.04	3,352,522.06
Ажиллагчидтай холбогдсон авлага		2,639,951.34	3,352,522.06
Төлбөртэй үйлчилгээний авлага		102,834,825.70	
<u>БАРАА МАТЕРИАЛ</u>	6	261,318,001.30	224,612,559.85
Түүхий эд материал		104,859,247.30	96,602,395.85
Тусгай зориулалтын материал		12,611,177.35	11,300,260.35
Эм боох материал		92,248,069.95	85,302,135.50
Хангамжийн материал		156,458,754.00	128,010,164.00
Бичиг хэрэг		3,603,995.00	2,955,275.00
Аж ахуйн материал		9,960,350.00	9,586,650.00
Сэлбэг хэрэгсэл		302,000.00	302,000.00
Барилгын засварын материал		990,000.00	990,000.00
Хүнсний материал		27,426,170.00	
Түлш, шатах тослох материал		60,128.00	60,128.00
Бусад хангамжийн материал		114,116,111.00	114,116,111.00
<u>НӨӨЦИЙН БАРАА</u>			
<u>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</u>			
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		478,900,901.46	227,965,081.91
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
<u>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</u>	7	1,465,523,180.97	350,420,466.87
<u>Биет хөрөнгө</u>		1,465,523,180.97	350,420,466.87
Барилга, байгууламж		7,123,590,800.00	7,123,590,800.00
Хуримтлагдсан элэгдэл		(6,768,948,399.80)	(6,773,170,333.13)
Авто- тээврийн хэрэгсэл		55,177,266.40	55,177,266.40
Хуримтлагдсан элэгдэл		(55,177,266.40)	(55,177,266.40)
Машин, тоног төхөөрөмж		1,948,722,059.33	
Хуримтлагдсан элэгдэл		(904,787,682.93)	
Тавилга, аж ахуйн эд хогшил		141,162,072.40	
Хуримтлагдсан элэгдэл		(77,596,098.03)	
Бусад үндсэн хөрөнгө		7,767,230.00	
Хуримтлагдсан элэгдэл		(4,386,800.00)	
БИЕТ БУС ХӨРӨНГӨ		-	-
Программ хангамж		980,000.00	
Хуримтлагдсан элэгдэл		(980,000.00)	
<u>БУСАД ХӨРӨНГӨ</u>	8		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,465,523,180.97	350,420,466.87
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1,944,424,082.43	578,385,548.78
Богино хугацаат өр төлбөр			
Өглөг	9	1,170,982,120.08	1,778,754,240.50
Ажиллагчидтай холбогдсон өглөг		1,170,982,120.08	1,778,754,240.50
Бусад өглөг		1,031,233,153.38	1,320,358,358.28

Байгууллагад төлөх өглөг		1,027,210,153.38	1,315,740,665.28
Хувь хүмүүст төлөх өглөг		4,023,000.00	4,617,693.00
<u>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</u>		2,202,215,273.46	3,099,112,598.78
<u>УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН</u>		-	-
<u>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</u>		2,202,215,273.46	3,099,112,598.78
Засгийн газрын хувь оролцоо		(257,791,191.03)	(2,520,727,050.00)
Засгийн газрын оруулсан капитал		549,910,480.39	-
- төрийн		549,910,480.39	
Дахин үнэлгээний нэмэгдэл		1,025,187,823.14	
Хуримтлагдсан үр дүн		(1,832,889,494.56)	(2,520,727,050.00)
Өмнөх үеийн үр дүн		(961,695,536.67)	(1,832,889,494.56)
Тайлан үеийн үр дүн		(871,193,957.89)	(687,837,555.44)
<u>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН</u>		(257,791,191.03)	(2,520,727,050.00)
<u>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</u>		1,944,424,082.43	578,385,548.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Тод руулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</u>			
<u>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>		4,424,791,564.00	-
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		277,635,300.00	
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		4,147,156,264.00	-
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		4,147,156,264.00	
Бараа, үйлчилгээний орлого		228,641,987.00	978,721,983.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого		196,298,987.00	17,419,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		89,429,335.00	17,349,000.00
Туслах үйл ажиллагааны орлого		106,869,652.00	70,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал		32,343,000.00	
Тусламжийн орлого			961,302,983.00
Хандив тусламж			961,302,983.00
Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого			961,302,983.00
<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</u>	2	4,653,433,551.00	978,721,983.00
<u>АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u>		3,641,468,119.32	929,214,665.48
<u>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</u>		3,249,310,492.91	763,140,632.95
Цалин		1,908,382,707.60	524,536,188.58
Цалингийн тусгай нэмэгдлүүд		1,007,769,872.29	208,678,358.39
Унаа хоолны хөнгөлөлт		115,756,780.00	29,926,085.98
Урамшуулал		217,401,133.02	
Нийгмийн хамгааллын шимтгэл		392,157,626.41	166,074,032.53
Тэтгэврийн даатгал		275,560,744.78	140,000,056.74
Тэтгэмжийн даатгал		32,149,308.01	7,220,568.43
ҮОМШӨ-ний даатгал		19,044,965.84	4,557,011.52
Эрүүл мэндийн даатгал		52,539,386.11	11,533,930.57
Ажилгүйдлын даатгал		12,863,221.67	2,762,465.27
<u>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</u>		1,775,728,419.07	120,955,466.94

Тогтмол зардал		253,025,097.31	-
Үйл ажиллагааны зардал		1,041,866,442.43	21,694,151.45
Эм		562,311,292.43	10,818,481.45
Хоол		479,555,150.00	10,875,670.00
Бусад бараа үйлчилгээний зардал		480,836,879.33	99,261,315.49
Бичиг хэргийн материал		6,770,480.00	1,390,610.00
Тээвэр, шатахууны зардал		14,555,401.00	
Шуудан холбооны зардал		39,979,813.00	17,405,830.00
Хог хаягдал, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		35,455,300.00	3,400,000.00
БҮТЭЭ		3,347,800.00	
Бараа материал акталсны зардал		6,067,522.50	
Бараа үйлчилгээний бусад зардал		8,794,350.00	798,800.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		7,000,000.00	
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		800,000.00	
Урсгал засварын зардал		27,508,840.00	1,306,000.00
Багаж, техник, хэрэгсэл		3,785,000.00	
Дотоод албан томилолт		1,620,000.00	
Газрын төлбөр		24,609,316.00	
Мэдээлэл технологийн үйлчилгээ		11,750,000.00	5,000,000.00
Элэгдлийн зардал		288,793,056.83	69,960,075.49
Урсгал шилжүүлэг		107,430,970.50	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		106,030,970.50	
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		1,400,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3	5,524,627,508.89	1,050,170,132.42
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		(871,193,957.89)	(71,448,149.42)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО			
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)			
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ			616,389,406.02
Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө			616,389,406.02
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		-	(616,389,406.02)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		(871,193,957.89)	(687,837,555.44)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
Татаас, санхүүжилтийн орлого	4,104,402,788.30	899,777,359.65
Нийгмийн даатгалын сангаас	4,104,402,788.30	899,777,359.65
Эрүүл мэндийн даатгалын сангаас	4,104,402,788.30	899,777,359.65
Бараа, үйлчилгээний орлого	473,934,287.00	14,249,000.00
Өмчийн орлого		
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхжүүих	89,429,335.00	14,249,000.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	384,504,952.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,578,337,075.30	914,026,359.65
Ажиллагчидтай холбогдсон зардал	3,188,297,667.61	598,112,166.86
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,751,662,367.61	598,112,166.86
Цалин	1,421,652,313.32	416,641,960.73
Цалингийн тусгай нэмэгдлүүд	996,852,141.27	156,820,706.13
Унаа хоолны хөнгөлөлт	115,756,780.00	24,649,500.00
Урамшуулал	217,401,133.02	
Нийгмийн хамгааллын шимтгэл	436,635,300.00	-
Тэтгэврийн даатгал	436,635,300.00	
Бараа, үйлчилгээний урсгал зардал	1,174,557,126.94	-
Тогтмол зардал	387,645,695.64	-
Гэрэл цахилгааны зардал	110,717,217.65	
Түлш, халаалтын зардал	170,455,919.30	
Цэвэр, бохир усны зардал	106,472,558.69	
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	646,849,453.30	-
Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	463,041,153.30	
Хоол, хүнс	183,808,300.00	
Бусад бараа үйлчилгээний зардал	140,061,978.00	-
Бичиг хэргийн материал	7,654,200.00	
Тээвэр, шатахууны зардал	13,900,000.00	
Шуудан холбооны зардал	27,829,813.00	
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	17,093,000.00	
БҮТЭЭ	19,040,510.00	
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	840,000.00	
Маягт хэвлүүлэх зардал	2,819,900.00	
Багаж техник хэрэгсэл	4,785,000.00	
Урсгал засварын зардал	22,999,555.00	
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	14,100,000.00	
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,000,000.00	
Урсгал шилжүүлэг	107,430,970.50	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	106,030,970.50	
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	1,400,000.00	
Төвлөрүүлэх шилжүүлэг		428,022,315.91
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	4,470,285,765.05	1,026,134,482.77
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	108,051,310.25	(112,108,123.12)

Хөрөнгийн орлого		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(IV)	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V)	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V)	-	-
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII)	108,051,310.25	(112,108,123.12)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,056,812.87	112,108,123.12
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	112,108,123.12	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	549,910,480.39	1,025,187,823.14	(961,695,536.67)	613,402,766.86
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга				-
Залруулсан үлдэгдэл	549,910,480.39	1,025,187,823.14	(961,695,536.67)	613,402,766.86
Тайлант үеийн үр дүн			(871,193,957.89)	(871,193,957.89)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	549,910,480.39	1,025,187,823.14	(1,832,889,494.56)	(257,791,191.03)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга	(549,910,480.39)	(1,025,187,823.14)		(1,575,098,303.53)
Залруулсан үлдэгдэл	-	-	(1,832,889,494.56)	(1,832,889,494.56)
Тайлант үеийн үр дүн			(687,837,555.44)	(687,837,555.44)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	(2,520,727,050.00)	(2,520,727,050.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	2,859,575,300.00	471,755,043.74	2,387,820,256.26	16.5
Нийгмийн даатгалын сангаас	2,859,575,300.00	471,755,043.74	2,387,820,256.26	16.5
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,859,575,300.00	471,755,043.74	2,387,820,256.26	16.5
Бараа, үйлчилгээний орлого	1,891,057,700.00	14,249,000.00	1,876,808,700.00	0.8
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,676,371,200.00	14,249,000.00	1,662,122,200.00	0.8
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	102,578,400.00		102,578,400.00	-
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	112,108,100.00		112,108,100.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,750,633,000.00	486,004,043.74	4,264,628,956.26	10.2
Ажиллагчидтай холбогдсон зардал	3,486,250,800.00	598,112,166.86	2,888,138,633.14	17.2
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,955,524,000.00	598,112,166.86	2,357,411,833.14	20.2
Цалин	1,950,340,000.00	416,641,960.73	1,533,698,039.27	21.4
Цалингийн тусгай нэмэгдлүүд	400,000,000.00	156,820,706.13	243,179,293.87	39.2
Унаа хоолны хөнгөлөлт	455,184,000.00	24,649,500.00	430,534,500.00	5.4
Урамшуулал	150,000,000.00		150,000,000.00	
Нийгмийн хамгааллын шимтгэл	530,726,800.00		530,726,800.00	
Тэтгэврийн даатгал	412,505,900.00		412,505,900.00	
Тэтгэмжийн даатгал	29,555,200.00		29,555,200.00	
ҮОМШӨ-ний даатгал	14,777,600.00		14,777,600.00	
Ажилгүйдлийн даатгал	14,777,600.00		14,777,600.00	
Эрүүл мэндийн даатгалын хураамж	59,110,500.00		59,110,500.00	
Бараа, үйлчилгээний урсгал зардал	1,159,103,800.00		1,159,103,800.00	
Тогтмол зардал	572,816,000.00		572,816,000.00	
Гэрэл цахилгааны зардал	150,000,000.00		150,000,000.00	
Түлш, халаалтын зардал	290,000,000.00		290,000,000.00	
Цэвэр, бохир усны зардал	132,816,000.00		132,816,000.00	
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	494,367,400.00		494,367,400.00	
Эм	374,367,400.00		374,367,400.00	
Хоол	120,000,000.00		120,000,000.00	
Бусад бараа үйлчилгээний зардал	91,920,400.00	-	91,920,400.00	
Бичиг хэргийн материал	2,000,000.00		2,000,000.00	
Тээвэр, шатахууны зардал	5,000,000.00		5,000,000.00	
Шуудан холбооны зардал	20,000,000.00		20,000,000.00	
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,667,000.00		16,667,000.00	
БҮТЭЗ	18,700,000.00		18,700,000.00	
Маягт хэвлүүлэх зардал	3,000,000.00		3,000,000.00	
Багаж, техник хэрэгсэл	5,153,400.00		5,153,400.00	

Урсгал засварын зардал	13,000,000.00		13,000,000.00	
Даатгалын үйлчилгээ	1,500,000.00		1,500,000.00	
Тээврийн хэрэгслийн татвар	1,500,000.00		1,500,000.00	
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,500,000.00		1,500,000.00	
Газрын төлбөр	1,500,000.00		1,500,000.00	
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,400,000.00		2,400,000.00	
Урсгал зардлын дүн	105,278,400.00		105,278,400.00	
Бусад урсгал шилжүүлэг	105,278,400.00		105,278,400.00	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	102,578,400.00		102,578,400.00	
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	2,700,000.00		2,700,000.00	
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,750,633,000.00	598,112,166.86	4,152,520,833.14	12.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		112,108,123.12		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-	

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн 2025 оны аудитаар нийт 769,531.9 мянган төгрөгийн зөрчил¹илэрч 6 зөвлөмжийг дээд шатны төсөв захирагчид хүргүүлж байна.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан дээр ЭМД-ын санхүүжилтийн орлого дутуу тайлагнасан.	1	310,404.0					1	310,404.0		
Харилцахын хуулгаар кассын орлого тушаасан боловч кассын бүртгэл, тайлан хөтлөлдөггүй байна.	1	8,811.0					1	8,811.0		
Тайлант онд худалдан авах ажиллагааны хууль, журам мөрдөөгүй эм эмнэлгийн хэрэгсэл шууд худалдан авсан байна.	1	99,256.9					1	99,256.9		
Санхүүгийн тайланд газар бүртгэлгүй боловч өмнөх оны газрын төлбөр 3 дүүргийн татварын албанд тайлагнаж өр үүсгэсэн	1	48,821.9					1	48,821.9		
СХДНЭ-т бараа материалыг хүлээлцсэн боловч, данс бүртгэлээс хасаагүй байна.	1	224,612.6					1	224,612.6		
Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.	1	77,625.6					1	77,625.6		
ДҮН	6	769,531.9					6	769,531.9		

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.